



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

### Төсвийн тодотголын тухай

Дээд боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дугаар заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.5, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2023 оны үйл ажиллагааны төсвийн орлогыг нэгдүгээр хавсралтаар, төсвийн зарлагыг хоёрдугаар хавсралтаар, хөрөнгө оруулалт, бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тодотгол хийн өөрчлөн баталсугай.

2. Төсвийг хууль, тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнан ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал (Т.Намнан)-д даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 09 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.БАТТОГТОХ



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

### Төсөв батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дугаар заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.5, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2024 оны төсвийн орлогыг нэгдүгээр хавсралтаар, төсвийн зарлагыг хоёрдугаар хавсралтаар, хөрөнгө оруулалт, бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан төсвийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнан ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал (Т.Намнан)-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТТОГТОХ



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот


### Гүйцэтгэх удирдлагын ажлын үр дүнг үнэлэх тухай

Боловсролын ерөнхий хуулийн 34 дугаар зүйлийн 34.1 дүгээр заалт, Дээд боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5, 27.1.6, 27.1.9 дүгээр заалтууд, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2 заалтууд, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 18-н өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. ШУТИС-ийн “2023 оны Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний биелэлтийг “Бүрэн хэрэгжсэн” хэмээн үнэлсүгэй.

2. ШУТИС-ийн 2023 оны Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн танилцуулахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал (Т.Намнан)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТТОГТОХ



54

## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

### Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн хуулийн этгээдийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13.4 дүгээр зүйл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.11, 22 дугаар зүйлийн 22.1, Боловсрол, шинжлэх ухааны яамны 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 6/5361 дугаартай албан бичиг, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Улсын бүртгэлд Шинжлэх ухаан технологийн их сургуулийн хэлбэрийг “төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар” гэснийг залруулан “боловсролын сургалтын байгууллага /сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн, дээд боловсрол/ гэж өөрчлөхийг дэмжсүгэй.

2. Хуулийн этгээдийн хэлбэрийн өөрчлөлтийг холбогдох хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлэхийг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал (Т.Намнан)-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТТОГТОХ